



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнийн баталсан ажлын дэд хэсэгт дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Одгэрэл

Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын дарга

Гишүүд:

Д.Бямбасүрэн

Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний
нисэхийн бодлого зохицуулалтын газрын
ахлах мэргэжилтэн

Г.Батбаяр

Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын
газрын дарга

Д.Хатанбаатар

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

П.Ариунболд

Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын
газрын дарга

Ч.Дарьсүрэн

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт,
зохицуулалтын албаны Нислэгийн
стандарт, үйл ажиллагааны хяналтын
хэлтсийн Газрын үйлчилгээ хариуцсан
ахлах байцаагч

Э.Төрбаяр

Иргэний нисэхийн үндэсний төвийн
Агаарын навигацийн үйлчилгээний газрын
дарга

Г.Ундраа

Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн
хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Р.Амарбаясгалан

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хамтын
ажиллагааны газрын дарга

2.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл
хангах ажилд бүх талын дэмжлэг үзүүлэн ажиллахыг ажлын хэсэг (Ч.Одгэрэл)-т
даалгасугай.

3.Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төсөвлөн
зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА